

ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕИЙН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEM EMERGENCY ASPECTS OF COOPERATION BETWEEN LAW ENFORCEMENT AGENCIES



Б.БАЯНМӨНХ

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн дэд профессор, докторант, цагдаагийн хошууч

BAYANMUNKH B.

Assistant professor of Police administrative department,
Police school of Law Enforcement university, Police major

Товч агуулга: Дэлхийн улс орнуудын хөгжилд учруулж байгаа байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөөс үүсэх аюул нь хамарч буй нутаг дэвсгэр, үргэлжлэх цаг хугацаанаасаа хамаарч үр дагаврынх нь цар хүрээ өөр өөр байдаг. Энэ илтгэлээрээ дээрх аюулын эсрэг ажиллаж байгаа хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, тэр дундаа харилцан ажиллагааны явцад анхаарах зарим асуудлын талаар дурдсан болно.

Abstract: The article is about that the compass of deduction is variety from disaster du-
ration at the territory. The disaster base from human activite and natural that worlds countries
development. This report about law enforcement agencies cooperation above disaster, some
problems on special time's of communtcation activity.

Түлхүүр үгс: Онцгой нөхцөл байдал, хамтын ажиллагаа, хууль сахиулах байгууллага.
Key words: Emergency, cooperation, law enforcement agency.

Үндсэн асуудал

Өнөө үед дэлхий дээр тохиолдож байгаа гамшиг буюу байгалийн аюулт үзэгдэл, хүний хүчин зүйлээс хамааралтай осол, сүйрэл, эмх замбараагүй байдал, террорист халдлага, бүс, нутгийн мөргөлдөөн жилээс жилд өсч, түүнээс учрах хор уршиг, үр дагавар улам бүр нэмэгдэж байгаагаас тэдгээрээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хор уршгийг арилгах явдал дэлхийн улс орнуудын өмнө тулгамдаж байгаа асуудал болж байна.

Түүний гаралтыг зөнд нь орхих бус, харин хууль сахиулах байгууллагууд түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, үр дүнтэй хэлбэрээр харилцан, хамтарч явуулбал учруулах хор аюулын хэр хэмжээг бууруулах бүрэн боломжтой.

Хууль сахиулах байгууллагуудын харилцан, хамтын ажиллагааны үр дүн нь тэдгээрийн хамтын удирдлагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, харилцан ажиллагааны дадал, зарлан мэдээлэл, бэлэн байдал, учирч болох эрсдэлийн үнэлгээ, иргэдийн ухамсар, боловсролын түвшин, мэргэжилтэй хүний нөөц, тэдгээрийн ур чадвар болон үйл ажиллагаанд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт, учирч болох хор аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох

хүч хэрэгслийн зөв оновчтой байршуулсан зэргээс ихээхэн хамааралтай байна.

Хууль сахиулах байгууллагуудын хамтран оролцож байгаа аливаа онцгой нөхцөл байдал бүрт дүн шинжилгээ хийснээр тодорхой мөчлөг, үе шатыг дамжиж үйл явц өрнөснийг тодорхойлж болно. Аливаа онцгой нөхцөл байдал эхлэл, өрнөл, оргил цэг, бууралт, тогтвортой байдал, төгсгөл гэсэн үндсэн үе шатуудыг туулдаг.

Онцгой нөхцөл байдлыг урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан таамаглах боломжтой хэмээн ангилах нь тухайн үүссэн нөхцөл байдлын үед тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг удирдах үйл явцыг зохицуулах боломжийг олгодог.

Урьдчилан таамаглаагүй онцгой нөхцөл байдлын үеийн хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг нэг гарт зангидаж, удирдаж чиглүүлэх нь үргэлж хялбар бус байдаг. Учир нь ийм нөхцөл байдалд үйл явц аль чигт, хэрхэн өрнөх, хамрах хүрээг тооцоолох боломж муу байдаг.

Түүнээс гадна тухайн нөхцөл байдлын цаг хугацааны болон мэдээллийн нөөцийн хомсдол нь хууль сахиулах байгууллагуудын хамтын удирдлагын шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлж байдаг. Ер нь урьдчилан таамаглаагүй үед үүссэн онцгой нөхцөл байдал нь хууль сахиулах байгууллагуудын удирдлагын системийн чадавхийг сорьж байдгаараа өвөрмөц байдаг. Харин урьдчилан таамаглаж болох онцгой нөхцөл байдлын хамтын ажиллагааг урьдаас төлөвлөж, түүнд бэлэн байж болдгоороо онцлогтой юм.

Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаанд олон хүчин зүйл сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байна. Тухайлбал:

1. Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны явцад тодорхой нөхцөлд харилцан ажиллах ур чадвар шаардахуйц онцгой нөхцөл байдал харьцангуй ховор тохиолддог, өөрөөр хэлбэл хууль сахиулах байгууллагууд тухайн нөхцөл байдалд өдөр бүр ажилладаггүй байдал;

2. Хууль сахиулах байгууллагуудын зарим удирдлага хамтын ажиллагаа, хамтран ажиллахын ач холбогдол, үр дүнг дутуу үнэлэх;

3. Хамтын ажиллаганы эрх зүйн орчин бүрдээгүй байх;

4. Тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын бүтэц боловсронгуй бус байгаагаас хоорондын үйл ажиллагаа уялдаа муутай байх;

5. Хамтын ажиллагааны явцад шаардлагатай төсвийн санхүүжилт дутагдах

6. Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны нэгдсэн удирдлагын штаб, түүний ажиллах дэд бүтцийг бүрдүүлээгүй байх;

7. Онцгой нөхцөл байдлын үед ажиллах алба хаагч, мэргэжилтэний нөөцийг бүрдүүлээгүй байх, тэднийг сургаж бэлтгээгүй байх, ур чадвар дутагдах зэрэг нь онцгой нөхцөл байдал үүссэн үеийн хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна.

Үүнээс гадна зарим онцгой нөхцөл байдал нь олон нийтийн сэтгэхүйд хүчтэй нөлөөлж, асуудлыг хүндрүүлэх явдал гардаг. Ийм нөхцөлд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг удирдаж чиглүүлэх үйл явцад бэрхшээл ихээр тулгарах болгодог.

Түүнчлэн, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд дараах нөхцөл байдал учирвал асуудал хүндэрч, үйл ажиллагаа хяналтаас гарч, үйл явцын өрнөл тооцоолж боломгүй түвшинд хүрэх байдал бий болж, хамтын ажиллагаанд хүндрэл үүснэ. Тухайлбал,

- Олон хүний амь насаа алдсан, эрүүл мэндэд нь ноцтой аюул

учирсан;

- Иргэд, олон нийтийн өмч хөрөнгөнд их хэмжээний хохирол учирч, асуудлыг шийдвэрлэхэд төсөв санхүүгийн боломж дутагдсан;

- Онцгой нөхцөл байдлын улмаас нэр алдартай хүмүүс, төрийн өндөр хэмжээний албан тушаалтан эрүүл мэндээрээ хохирсон, амь насаа алдсан;

- Хууль сахиулах байгууллагууд үүссэн нөхцөл байдалд маш их тулгамдаж шийдвэр гаргаж чадахгүй байх, ур чадвар дутагдах;

- Урьд өмнө тохиолдож байгаагүй онцгой нөхцөл байдал үүсч, түүнтэй тэмцэх туршлага дутагдах үед онцгой нөхцөл байдлын цар хүрээ өргөсөж хяналтаас гарах магадлал нь нэмэгдэж байдаг.

Онцгой нөхцөл байдлын үед ажиллах хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа бүрэн төлөвшиж чадаагүй, ажиллах алба хаагч, мэргэжилтэний нөөцийг бүрдүүлээгүй, тэднийг сургаж бэлтгээгүй, ур чадвар дутагдах, тухайн нөхцөл байдалд ажиллахад шаардлагатай төсөв, санхүүгийн эх үүсвэр дутагдах зэрэг нь онцгой нөхцөл байдлыг хор хохирол багатай гэтлэн давахад саад болж байна.

Цагдаагийн байгууллага дараах нөхцөл байдал бий болсон тохиолдолд дор дурдагдах хууль сахиулах болон бусад тусгай чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал

- Төрийн өндөр хэмжээний зочид төлөөлөгчдийн хамгаалалтанд Тагнуулын байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газар, Онцгой байдлын алба, Эмнэлгийн албад, Тахарын албатай

- Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед Мэргэжлийн хяналтын алба, Онцгой байдлын алба, Эмнэлгийн албадтай

- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулахад Тагнуулын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Онцгой байдлын алба, Тахарын алба, Мэргэжлийн хяналтын алба, Эмнэлгийн албадтай тус тус хамтран ажиллаж байна.

Бид өнөөдөр хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй болгохын тулд тодорхой нөхцөл байдалд харилцан ажиллах явцад тулгарах хүндрэл бэрхшээлийг бага гэлтгүй авч үзэх шаардлагатай байна.

Өнөөдөр хууль сахиулах байгууллагуудийн үйл ажиллагаанд онцгой байдал, онцгой нөхцөл байдал, гамшигт байдал, хямралт байдал гэх мэт нэр томьёонууд хэрэглэгдэж байна.

Бид онц байдлын өмнөх үеийн нөхцөл байдлыг хууль сахиулах байгууллагууд өөрсдийн чиг үүргийн онцлогоос хамаарч, өөр өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан томьёолж, эрх зүйн зохицуулалтандаа оруулсан байна. Тухайлбал:

Цагдаагийн байгууллага дээр дурдсан нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох төлөвлөгөөндөө "Онцгой нөхцөл байдал", Онцгой байдлын алба "Гамшиг", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага "Онцгой нөхцөл байдал/хямралт байдал", Хил хамгаалах байгууллага "Онцгой байдал" гэсэн нэр томьёог ашигладаг байна.

Тэгвэл цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хууль тогтоомж, эрх зүйн актанд "Онцгой нөхцөл байдал" гэсэн нэр томьёог

тодорхойлж өгөөгүй боловч өгөөд үүнд ямар нөхцөл байдлуудыг хамааруулан ойлгохыг Цагдаагийн албаны тухай хуулийн¹ 11-р зүйл (Олон нийтийн аюулгүй байдлыг хангах)-д зааснаар дараах нөхцөл байдлуудыг онцгой нөхцөл байдалд хамааруулан авч үздэг байна. Тухайлбал:

- Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлал
- Хууль бус жагсаал цуглааныг албадан тараах
- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал
- Гамшиг
- Террорист халдлага
- Онц байдал

Тэгвэл онцгой байдлын алба нь “Гамшиг” гэсэн нэр томъёогоор үйл ажиллагаа нь тодорхойлогдож байна. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т “Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг”² мөн “Онцгой байдал” гэж гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг онцгой ажиллагаа явуулж байгаа нөхцлийг”³ хэмээн тодорхойлсон байна.

Харин Хилийн алба “Улсын хил дээр гамшиг, аюул үзэгдэл тохиолдох, эмх замбараагүй байдал бий болох, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэг үйл ажиллагаа явуулах, өдөөн хатгалга, зэвсэгт халдлага, түрэмгий үйлдэгдэх нөхцөл байдал бий болсон үед хил хамгаалах байгууллагаас явуулах цогц арга хэмжээг онцгой байдлын үеийн хил хамгаалалт гэнэ”⁴ хэмээн тодорхойлж өгчээ.

Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага онцгой нөхцөл байдал гэсэн ойлголтонд “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”-ын хоёр зүйл заалтанд тодруулж өгсөн байна. Тухайлбал, уг журмын 2.3.4-д “ялтны гаргасан гэмт үйлдэл (бусдыг барьцаанд авах, зохион байгуулалттайгаар хорих ангийн дотоод дэг журам зөрчих, шаардлагад захирагдахгүй байх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, оргох)-ийг таслан зогсоох, эрэн сурвалжлах, 2.5-д заасан улс орны гадаад, дотоод байдал хүндэрсэн, байгалийн гамшиг тохиолдсон, нийтийг хамарсан хорио цээрийн дэглэм тогтоосон, албаны сургалт, дадлага болон бусад нэгдсэн ажиллагаанд хамрагдах үеийн нөхцөл байдал”⁵-уудыг хамааруулан үзсэн байна

Дээр дурдсан тодорхойлолт болон хамааруулан үзсэн нөхцөл байдлуудыг харахад бүгд ямар нэгэн байдлаар онцгой үйл явдал болж, тухайн байгууллага тусгайлсан журмаар үйл ажиллагаа нь зохицуулагдахаар байгаа хэдий ч бүгд өөр өөрсдийн онцлог үйл ажиллагаатай холбоотойгоор тодорхойлсон нь харагдаж байна. Энэ бүгдийг дүгнэж үзээд онцгой нөхцөл байдал гэсэн ойлголтыг дараах байдлаар томъёолж болохоор байна.

¹ Төрийн мэдээлэл. 2013. №29

² “Төрийн мэдээлэл”. УБ. 1992. №1

³ Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн эмхтгэл. УБ. 2008. 127 дахь тал

⁴ Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм /II дэвтэр/-ийн 8-р бүлгийн 263 дэх хэсэг

⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 51 дугаар тушаалаар батлагдсан “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”-ын 401 дэх тал

“Онцгой нөхцөл байдал” гэж Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэг, объект, барилга байгууламжид ажиллаж байгаа болон оршин суугаа иргэд, олон нийтийн амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, тэдний аюулгүй байдал, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар аюул учруулахуйц байдал үүсч түүнийг тусгай чиг үүргийн төрийн байгууллага өөрийн эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр хэвийн байдалд оруулах боломжгүй болсон эсвэл 2 буюу түүнээс дээш тусгай чиг үүргийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд тухайн үзэгдэл, үйл явц хэвийн байдалд орох боломжтой, гэнэтийн өөрчлөлтийн үр дүнд үүссэн аюултай нөхцөл, байдлыг ойлгоно.

Эндээс үзэхэд онцгой нөхцөл байдал нь үүсгэж буй хүчин зүйл, түүнээс учруулсан хор уршгийн хэр хэмжээ, хууль сахиулах байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс ихээхэн хамаарах бөгөөд гагцхүү эрх зүйн тодорхой дэглэм, харилцан хамтын ажиллагаагаар үйл ажиллагаа нь зохицуулагддагаараа бусад ердийн үйл ажиллагаануудаас ялгагдана.

Өнөөдөр онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн байгууллагуудын хамтын ажиллагаанд бас зүйл шаардлагатай байгааг анхааралдаа авч үзэх зүйл бол үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хэт богино долгионы радио станцаар нэвтрүүлэхэд хэрэглэгдэх кодны асуудал юм.

ЦЕГ-ын даргын 2011 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 569 тоот тушаалаар богино долгионы радио долгионоор удирдлагаас өгөх команд, харилцах кодыг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнийг төрийн байгууллагууд онцгой нөхцөл байдлын үеийн хамтын ажиллагаандаа ашиглах шаардлага бий болсон байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэргийн тухай мэдээллийг хэт богино долгионы радио станцаар дамжуулахдаа код хэрэглэснээр албадын хамтын ажиллагаа, бие биедээ мэдээлэл дамжуулах явдал нь түргэн шуурхай болох бөгөөд төрөл мэргэжлийн албадын хамтын ажиллагааны үр нөлөө эрс дээшилсэн байна. Жишээлбэл, хүн амины гэмт хэрэг №01, хүчиндэх №02, дээрэмдэх №03 гэх мэт 15 тодорхой төрлийн гэмт хэргүүдийг кодолсноор мэдээллийг түргэн шуурхай дамжуулах нөхцөл бүрдсэнээр цагдаагийн төрөл мэргэжлийн албадын хамтын ажиллагаа сайжирна.

Тэгвэл бид өнөөдөр дээрх арга барилаар үргэжлүүлэн онцгой нөхцөл байдлын үед үүсэх зарим нэг үзэгдэл, үйл явцыг кодлож өгснөөр хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээллийг түргэн шуурхай дамжуулах нөхцөл боломж бүрдэж, хамтын ажиллагаа сайжирна. Тухайлбал, гал түймэр гарах №16, газар хөдлөлт №17, химийн болон цацраг идэвхит хорт бодис алдагдах №18, тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой хэрэг №19, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал №20, Үер усны аюул №21, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин №22 гэх мэтээр хууль сахиулах байгууллагууд хамтран ажиллах болох нөхцөл байдлуудыг кодлож, харилцан ажиллагаа сайжирч, учирч болох аюулыг бууруулах боломжтой

болно.

Тэгэхдээ кодлохдоо үзэгдэл, үйл явцын өрнөл, бусдад учруулах хор аюулын хэр хэмжээ, нийгэм, олон нийтэд нөлөөлөх хүчин зүйлсүүдийг харгалзан шат дараалан дугаарлах нь зүйтэй болов уу.

Түүнчлэн, онцгой нөхцөл байдлын үед хийгддэг зарим ажиллагаануудыг цагдаагийн байгууллагуудын зарим тодорхой ажиллагаанд өгөгдөг командуудыг ашиглан нэр өгч, харилцан мэдээлэл дамжуулахдаа ашиглавал хамтын ажиллагааны үр нөлөө дээшлэх боломжтой.

Тухайлбал, цагдаагийн байгууллага нь “галаас урьдчилан сэргийлэх, унтраах ажиллагаа”-г гялбаа хэмээн удирдлагаас команд өгдөг байна. Бид үүнийг хамтын ажиллагаандаа ашиглавал түргэн шуурхай, үр дүнтэй ажиллагаа болох болно.

Дараагийн нэг асуудал бол онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллаж байгаа хууль сахиулах байгууллагуудын радио торны дуудлагын асуудал юм. Хэдийгээр онцгой нөхцөл байдлын үед төрийн байгууллагуудын удирдлагуудын ерөнхий дуудлага хоорондоо давхцахгүй байгаа хэдий боловч тэдгээрийн харьяалалд байгаа анги, салбар, албадуудын дуудлагын нэршил нь бусад байгууллагуудын дуудлагатай давхцах байдал байсаар байна. Үүнийг цэгцлэхгүй бол хоорондоо буруу ойлголцох байдал гарахыг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал

- Хорих 423-р анги (хархорин) болон ЦЕГ-ын Олон нийтийн аюулгүй газрын Хамгаалалтын 2-р газрын радио холбооны дуудлага нь “Орхон”
- Хорих 401-р анги (дамжин) болон ЦЕГ-ын Олон нийтийн аюулгүй газрын хамгаалалтын 3-р газрын радио холбооны дуудлага нь “Уянга”
- Хорих 411-р анги (хүүхэд) болон ХХЕГ-ын радио холбооны дуудлага нь “Тайхар”
- Хорих 413-р анги (Зүүнхараа) болон ТЕГ-ын радио холбооны дуудлага нь “Харцага” гэсэн нэг дуудлагатайгаар хоорондоо давхцдаг байна.

Түүнээс гадна хууль сахиулах байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаанд саад болохуйц нэг зүйл бол тэдний хэрэглэж, ашиглаж байгаа техник, технологитой холбоотой асуудал юм. Өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагуудад ашиглагдаж байгаа холбооны хэрэгслүүд нь өөр өөр улсад үйлдвэрлэгдсэн, янз бүрийн хүчин чадалтай радио богино долгионы станцуудыг ашиглаж байгаа нь хоорондоо холбоо тогтоох, харилцан ажиллагаанд тодорхой хүндрэл учирч болохыг үгүйсгэх аргагүй юм.

Дээрх бүгд асуудлыг авч үзээд дараах саналуудыг дэвшүүлж байна.

Үүнд:

1. Онцгой нөхцөл байдал гэсэн нэр томъёог нэгдсэн нэг ойлголттойгоор тодорхойлж, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад тусгаж өгөх;

2. Онцгой нөхцөл байдлын үед ашиглагдаж байгаа хууль сахиулах байгууллагууд, тэдгээрийн салбар нэгжүүдийн дуудлагуудын нэршлийг нэгдсэн нэг зохицуулалтанд оруулж, давхцалыг арилгах;

3. Хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаанд пролоор харьцах аргыг нэвтрүүлэх;

4. Онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, түүний эрх зүйн орчинд нарийвчилсан судалгаа хийлгэж, тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг нарийвчлан тодорхойлох;

5. Онцгой нөхцөл байдлын үед ажиллах хууль сахиулах байгууллагуудыг холбоо мэдээллийн техник, технологийн хамгийн сүүлийн үеийн нэг загварын хүчин чадал бүхий богино долгионы радио станцаар хангах.

Анхаарал тавьсанд баярлалаа!